

МОНГОЛ УЛС  
ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2003 оны 8 дугаар  
сарын 06-ны өдөр

Дугаар 59

Улаанбаатар  
хот

Түр журам батлах тухай

“Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 19.2.11, 20.4.1 дэх заалтыг үндэслэн  
Үнэт цаасны хорооноос ТОГТООХ нь:

1. “Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын эргэлтийн хөрөнгийн доод хэмжээг тогтоох болон болзошгүй эрсдэлээс хамгаалах тухай” түр журмыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх журмыг үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагад сурталчлан, мөрдөж ажиллахыг Зах зээл зохицуулалтын хэлтэс /Ц.Норовдондог/-т даалгасугай.

3. Энэхүү түр журмыг мөрдөх явцад гарсан эерэг, сөрөг талууд болон цаашид боловсронгуй болгох талаарх санал боловсруулж 2003 оны IY улиралд багтаан Хорооны хуралдаанд оруулж шийдвэрлүүлэхийг Ажлын алба /Ж.Жадамбаа/-нд үүрэг болгосугай.

ДАРГА

С.ГҮНДЭНБАЛ

Үнэт цаасны хорооны 2003 оны  
08 дугаар сарын 06-ны өдрийн  
59 дүгээр тогтоолын хавсралт

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ОРОЛЦОГЧ МЭРГЭЖЛИЙН  
БАЙГУУЛЛАГЫН ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДООД  
ХЭМЖЭЭГ ТОГТООХ БОЛОН БОЛЗОШГҮЙ ЭРСДЛЭЭС  
ХАРИЛЦАГЧДЫГ ХАМГААЛАХ САН БАЙГУУЛАХ ТУХАЙ  
ТҮР ЖУРАМ

НЭГ.Нийтлэг үндэслэл

1.Энэхүү журмаар “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 19.2.11; 20.4.1 дэх заалтыг хэрэгжүүлж үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагаас харилцагчдад учирч болзошгүй санхүүгийн эрсдлээс харилцагчдыг хамгаалах сан байгуулах, эргэлтийн хөрөнгийн доод хэмжээг тогтоож мөрдүүлэх болон эрсдлийн санг байршуулах, нөхөн төвлөрүүлэх, санхүүгийн тайланд тусгахад чиглэгдсэн харилцааг зохицуулна.

ХОЁР. Мэргэжлийн байгууллагуудын эргэлтийн  
хөрөнгийн болон эрсдлийн санд төвлөрүүлэх  
хөрөнгийн доод хэмжээ

2.1.“Хөрөнгийн бирж” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгөнд эргэлтийн хөрөнгийн эзлэх хэмжээ 30 хувиас доошгүй байх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийн 3 хувьтай тэнцэхүйц мөнгөн хөрөнгийг эрсдлийн санд төвлөрүүлнэ.

2.2.Дилерүүдийн арилжааны төвийн хувь нийлүүлсэн хөрөнгөнд эргэлтийн хөрөнгийн эзлэх хэмжээ 30 хувиас доошгүй байх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийн 3 хувьтай тэнцэхүйц мөнгөн хөрөнгийг эрсдлийн санд төвлөрүүлнэ.

2.3.Үнэт цаасны “Төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгөнд эргэлтийн хөрөнгийн эзлэх хэмжээ 75 хувиас доошгүй байх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 хувьтай тэнцэхүйц мөнгөн хөрөнгийг эрсдлийн санд төвлөрүүлнэ.,

2.4.Үнэт цаасны хамтын хөрөнгө оруулалтын байгууллага болон хөрөнгө оруулалтын сангийн хувь нийлүүлсэн хөрөнгөнд эргэлтийн хөрөнгийн эзлэх хэмжээ 75 хувиас доошгүй байх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 хувьтай тэнцэхүйц мөнгөн хөрөнгийг эрсдлийн санд төвлөрүүлнэ.

2.5.Брокер, дилерийн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөнд эргэлтийн хөрөнгийн эзлэх хэмжээ 30 хувиас доошгүй байх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийн 3 хувьтай тэнцэхүйц мөнгөн хөрөнгийг эрсдлийн санд төвлөрүүлнэ.

2.6.“Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 19.3 дахь заалтын дагуу даатгуулах замаар эрсдлээс хамгаалах арга хэмжээ авч болох бөгөөд даатгалын үнэлгээ нь энэ журмын 2 дугаар зүйлд заасан хэмжээнээс бага байх тохиолдолд мөнгөн хөрөнгөөр нөхөн гүйцээнэ.

ГУРАВ. Эрсдлийн санг байршуулах, нөхөн  
төвлөрүүлэх, санхүүгийн тайланд  
тусгах, тайлагнах

3.1. Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын болзошгүй эрсдлээс хамгаалах санг тухайн байгууллагын Арилжааны банк дахь харилцах дансанд байршуулж, дансны үлдэгдлийг эрсдлийн сангийн тогтоосон хэмжээнд байлгана.

3.2. Мэргэжлийн байгууллага нь эрсдэл гарсан тухай бүр хохирлыг барагдуулах бөгөөд эрсдлийн сангийн хөрөнгийг нөхөн төвлөрүүлж, анх тогтоосон хэмжээнд байлгана.

3.3. Сангийн хөрөнгийн санхүүгийн тайлангийн мөнгөн хөрөнгө хэсэгт эрсдлийн сан нэртэйгээр тусгана.

3.4. Эрсдэл гарсан тухай бүрт эрсдлийн хэлбэр, хохирлын хэмжээ, хэрхэн барагдуулсан болон сангийн хөрөнгийн нөхөн төвлөрүүлсэн талаарх тайлан, тус сангийн хөрөнгө энэхүү журамд заасан доод хэмжээнд байгаа зэрэг мэдээллийг Арилжааны банкны дансны хуулгаар баталгаажуулан Хороонд ирүүлнэ.

3.5. Хорооны Зах зээл зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын эрсдлийн сангийн тайлан, холбогдох баримтад дүгнэлт хийж хууль, журамд нийцүүлэх арга хэмжээ авна.

ДӨРӨВ. Хүлээлгэх хариуцлага

4.1. Энэхүү журмыг зөрчвөл Үнэт цаасны гүйлгээний хяналтын улсын байцаагч “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 38.1.1 дэх заалтын дагуу захиргааны шийтгэлийг ногдуулна.

---oOo---